



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ  
ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠦᠭᠢᠨ  
ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠭᠢᠨ  
ᠵᠠᠬᠢᠷᠠᠮᠵᠢ

**МОНГОЛ УЛС  
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

᠒᠐᠒᠒ оны ᠐7 сарын ᠐1 өдөр

Дугаар А/415

Алтай хот

Эрх шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3, 34 дүгээр зүйлийн 34.2 дахь хэсэг, 46 дугаар зүйлийн 46.1.8 дахь заалт, Засгийн газрын 2021 оны Босго үнэ шинэчлэх тухай 124 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэх Цогт сумын Төгрөг багийн төвийн барилгын засварын ажлыг шууд гэрээ байгуулан гүйцэтгүүлэх эрхийг Цогт сумын Засаг дарга (Л.Насанбуян)-т шилжүүлсүгэй.

2.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомжийн дагуу худалдан авах ажиллагааг зохион байгуулж шаардлага хангасан гүйцэтгэгчтэй гэрээ байгуулан, захиалагчийн хяналт, хариуцлагыг гэрээнд тодорхой тусгаж, хэрэгжилтэд хяналт тавьж, тайлагнаж ажиллахыг Цогт сумын Засаг дарга (Л.Насанбуян)-д үүрэг болгосугай.

3.Ажлын гүйцэтгэл, чанар, санхүүжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Г.Хурцгэрэл), Санхүү төрийн сангийн хэлтэс (Х.Баатарзориг) т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

О.АМГАЛАНБААТАР

